



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Нийслэлийн хэмжээнд эх барих,
эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ
үзүүлэх хүрээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 заалтыг тус тус үндэслэн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх улсын эрүүл мэндийн байгууллагуудын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хуваарийн дагуу тусламж, үйлчилгээг шуурхай зохион байгуулан ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буянжаргал), Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр), Нийслэлийн Эрүүл мэндийн газар (Л.Төмөрбаатар) -т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/362 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Я.Амаржаргал)-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



• 141200460

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
02 дүгээр сарын 20-ны өдрийн
А/130 дүгээр тушаалын хавсралт

ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУВААРЬ

	Байгууллагын нэр	Эх барихын тусламжийн үйлчлэх хүрээ	Эмэгтэйчүүдийн тусламжийн үйлчлэх хүрээ
1	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг	-Хөдөө орон нутгийн жирэмслэлт, төрөлттэй холбоотой тусламж, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 5-11, 24, 25, 28, 37, 40, 41, 42 дугаар хороо	-Баянгол, -Сонгинохайрхан дүүргийн бүх хороо, - Хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд
2	Нийслэлийн Өргөө амаржих газар	- Баянгол - Хан-Уул - Чингэлтэй - Багахангай дүүргийн бүх хороо	- Баянгол - Хан-Уул - Чингэлтэй - Багахангай дүүргийн бүх хороо
3	Нийслэлийн Хүрээ амаржих газар	Сонгинохайрхан дүүргийн 1-4, 12-23, 26, 27, 29-36, 38, 39, 43 дугаар хороо	-
4	Нийслэлийн Амгалан амаржих газар	-Баянзүрх - Сүхбаатар дүүргийн бүх хороо	-Баянзүрх - Сүхбаатар дүүргийн бүх хороо
5	Багануур Эрүүл мэндийн төв	Багануур дүүргийн бүх хороо	Багануур дүүргийн бүх хороо
6	Налайх Эрүүл мэндийн төв	Налайх дүүргийн бүх хороо	Налайх дүүргийн бүх хороо